

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ2022 оны 03 сарын 27 өдөрДугаар: 06

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах
тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3, 21.2.9 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Хөрөнгө зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. “Хөрөнгө зохицуулах журам” болон холбогдох хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо (Ц.Түмэнхишиг)-нд тус тус үүрэг болгосугай.


3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Хөрөнгө зохицуулах журам батлах тухай” 02/06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2022 оны 4 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



З.ЭНХБОЛД



ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хөрөнгө зохицуулах журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Үндэсний давхар даатгал ХК /цаашид “компани” гэх/-ийн дүрмийн 3.1 дэх хэсэгт заасан сан болон бусад сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой харилцааг зохицуулах, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/, Гүйцэтгэх захирал, Хөрөнгө зохицуулах хорооны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, эрх зүйн байдлыг тогтооход оршино.

1.2 Энэ журам нь Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Даатгалын багц дүрэм, Компанийн дүрэм болон бусад холбогдох дүрэм, журамд нийцсэн байна.

1.3. Хуульд энэ журамд зааснаас өөрөөр заасан бол хуулийн заалтыг дагаж мөрдөнө.

1.4. Энэхүү журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1. “Дүрмийн сан” гэж Компанийн дүрмийн 3.1-д заасан хөрөнгийг;

1.4.2. “Бие даасан сан” гэж Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27.1-д заасан сангийн хөрөнгийг;

1.4.3. “Нөхөн төлбөрийн нөөц сан” гэж энэ журмын 1.4.1, 1.4.2 болон Хамтын эрсдэлийн сангаас бусад хөрөнгийг;

1.4.4. “Их хэмжээний хэлцэл” гэж Компанийн тухай хуулийн 87.1 дэх хэсэгт заасныг;

1.4.5. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт заасныг;

1.4.6. “Хөрөнгө зохицуулах хороо” гэж /цаашид “хороо” гэх/ энэ журмын 1.4.1-

1.4.3-т заасан хөрөнгө /цаашид “Сангийн хөрөнгө” гэх/-ийг удирдахтай холбоотой Хөрөнгө оруулалтын шинжилгээнд тулгуурлан дүгнэлт гаргах чиг үүрэгтэй, Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан орон тооны бус ажлын хэсгийг;

1.4.7. “Хөрөнгө оруулалтын шинжилгээ” /цаашид “шинжилгээ” гэх/ гэж компанийн Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас сангийн хөрөнгийг удирдахтай холбогдуулан тухайн төрлийн хөрөнгө оруулалтын хэлбэрт тохирох аргад суурилсан, үнэн зөв баримт бичгийг;

1.4.8. “Сангийн хөрөнгийг удирдах” гэж сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад шинээр байршуулах, хугацааг сунгах, дахин байршуулах, буцаан татах ажиллагааг;

1.5. Сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

1.5.1. Эрсдэл, өгөөжийн зохистой харьцааг хангах;

1.5.2. Бодит судалгаа, тооцоонд үндэслэсэн байх;

1.5.3. Нууцыг хадгалах;

1.5.4. Хараат бус байх;

1.5.5. Хөндлөнгийн аливаа нөлөөнд автахгүй байх.

ХОЁР. САНГИЙН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ АЖИЛЛАГАА

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл

2.1.1. ТУЗ нь энэ журмын 1.4.4, 1.4.5-д заасан хэлцэл хийх эсэх зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд олгоно.

2.1.2. ТУЗ нь Гүйцэтгэх захирлаас энэ журмын 2.1.1-д заасан санал ирүүлснээс хойш ажлын 10 /арав/ өдрийн дотор зөвшөөрөл олгох, шийдвэр гаргах ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр энэ журмын 2.1.1-д заасан шийдвэр гаргаж, зөвшөөрөлгүйгээр хэлцэл хийсэн тохиолдолд гаргасан шийдвэр, хийсэн хэлцлийг өөрөө эсхүл ТУЗ-ийн шийдвэрээр хүчингүй болгож, учирсан хохирлыг Гүйцэтгэх захирлаар нөхөн төлүүлнэ.

2.1.4. ТУЗ-ийн ээлжит хуралдаанаар энэ журмын хэрэгжилт, Сангийн хөрөнгийн талаарх Гүйцэтгэх захирлын тайлантай танилцаж, холбогдох шийдвэрийг гаргаж болно.

2.2. Гүйцэтгэх захирал

2.2.1. Энэ журмын 1.4.4, 1.4.5-д зааснаас бусад хэлцэл хийх эсэх шийдвэрийг Хорооны дүгнэлтийг харгалзан, тус дүгнэлтийг ирүүлснээс хойш ажлын 2 /хоёр/ өдрийн дотор гаргана.

2.2.2. Сангийн хөрөнгийг удирдах асуудлаар банк болон бусад хуулийн этгээдтэй гэрээ, хэлцэл хийнэ.

2.2.3. Хорооны бүрэлдэхүүнийг энэ журмын 2.3.2-т заасан албан тушаалтнуудыг оролцуулан тушаалаар батална.

2.2.4. ТУЗ-ийн ээлжит хуралдаанд энэ журмын хэрэгжилт, Сангийн хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй тайланг танилцуулна.

2.3. Хөрөнгө зохицуулах хороо

2.3.1. Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

2.3.2. Хорооны бүрэлдэхүүнд дараах албан тушаалтнууд байна. Үүнд:

а. Дэд захирал;

б. Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газрын дарга;

в. Анддеррайтингийн газрын дарга;

г. Компаенс, нөхөн төлбөрийн газрын дарга;

д. Захиргаа, удирдлагын газрын дарга;

2.3.3. Хөрөнгө зохицуулах хороог Дэд захирал удирдаж, хорооны хурлыг даргална.

2.3.4. Хороо нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд Хөрөнгө оруулалтын шинжээч ажиллана. Нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй байх ба дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

а. Хороог аливаа үнэн зөв мэдээ, мэдээллээр цаг алдалгүй, шуурхай хангах;

б. Хорооны хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг хангах;

в. Хорооны хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах;

г. Хорооны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хариуцах.

2.4. Хороо нь дараах эрх үүрэгтэй. Үүнд:

2.4.1. Сангийн хөрөнгийг удирдах талаар Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас ирүүлсэн шинжилгээг үндэслэн, Хавсралт 1-д заасан маягтын дагуу дараах шийдвэрийн аль нэгийг тусгасан дүгнэлт гаргана. Үүнд:

а. Зөвшөөрсөн;

б. Татгалзсан;

в. Нэмэлт судалгаа хийлгэхээр буцаасан;

2.4.2. Хорооноос энэ журмын 2.4.1 дэх хэсгийн "б"-д зааснаар дүгнэлт гаргасан бол Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас шинжилгээг шинэчлэн боловсруулж, эсхүл өөр хөрөнгө оруулалтын хэлбэрийг тусган Хөрөнгө зохицуулах хороонд дахин хүргүүлж болно.

2.4.3. Хороо нь сангийн хөрөнгийг удирдах талаар тухайн хэлцлийн хугацаа дуусах, эсхүл эхлэхээс 15 хоногийн өмнө энэ журмын 2.4.1-д заасан дүгнэлт гаргаж Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.

2.4.4. Сангийн хөрөнгийн талаар ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх захирлыг холбогдох мэдээллээр хангана.

2.4.5. Сангийн хөрөнгийг удирдах талаар ТУЗ, Гүйцэтгэх захирлаас энэ журамд заасны дагуу шийдвэр гарсны дараа хорооны нарийн бичгийн дарга энэ тухай ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд цахим хэлбэрээр ажлын 1-3 /нэгээс - гурав/ өдрийн дотор хүргүүлнэ.

2.4.6. Хороо нь энэ журмын 2.4.1-д заасан дүгнэлтийг Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас холбогдох шинжилгээг ирүүлснээс хойш ажлын 3 /гурав/ хоногийн дотор гаргаж, шинжилгээ, хорооны хурлаас гарсан дүгнэлт, хурлын тэмдэглэлийн хамт Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.

2.4.7. Хороо нь энэ журмын 2.4.1 дэх хэсгийн "в"-д зааснаар дүгнэлт гаргасан бол Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас шинжилгээг ажлын 5 /тав/ хоногийн дотор дахин хийж, Хөрөнгө зохицуулах хороонд ирүүлнэ.

2.4.8. Хороо нь энэ журмын 2.4.7-д зааснаар Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газраас дахин ирүүлсэн шинжилгээг ажлын 3 /гурав/ хоногийн дотор шийдвэрлэж, дүгнэлт, хурлын тэмдэглэл, хөрөнгө оруулалтын шинжилгээний хамт Гүйцэтгэх захиралд хүргүүлнэ.

2.4.9. Гүйцэтгэх захирал нь шаардлагатай гэж үзвэл Хорооны дүгнэлтийг дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.

2.4.10. Энэ журамд заасан мэдээлэлтэй танилцсан эрх бүхий этгээд сангийн хөрөнгийн талаарх холбогдох шинжилгээ, дүгнэлт, шийдвэртэй танилцах хүсэлт гаргавал хорооны нарийн бичгийн дарга хорооны даргын зөвшөөрлөөр нэн даруй хуулбар хувийг хүргүүлнэ.

2.4.11. Энэ журмын 2.4.1-д заасан дүгнэлтэд Хорооны бүх гишүүд гарын үсэг зурсан байна. Гарын үсэг зурахаас татгалзсан гишүүн шийдвэрээс эсрэг саналтай бол энэ талаарх тусгай саналаа бичгээр гаргаж, шийдвэрт хавсаргана.

2.4.12. Хороо нь аливаа асуудлыг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэх ба шийдвэрт дараах зүйлсийг заавал тусгана. Үүнд:

- а. Шийдвэр гаргасан он, сар, өдөр;
- б. Хорооны хуралд оролцсон гишүүдийн овог, нэр;
- в. Хурлаар хэлэлцсэн асуудал;
- г. Санал хураалтын үр дүн;
- д. Хэлэлцсэн хөрөнгө оруулж болох бусад боломжит хэлбэр;
- е. Хорооны гишүүдээс тусгай санал гаргасан эсэх.

2.5. Гүйцэтгэх захирал энэ журмын 1.4.4, 1.4.5-д зааснаар зөвшөөрөл авахдаа холбогдох тооцоо, хэлцлийн үр дагавар зэрэг мэдээллийг тодорхой тусгасан байна.

ГУРАВ: САНГИЙН ХӨРӨНГИЙГ УДИРДАХ ХЭЛБЭР

3.1. Сангийн хөрөнгийг удирдах үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- 3.1.1. Банкны хадгаламж;
- 3.1.2. Банкны харилцах дансанд байршуулах;
- 3.1.3. Засгийн газрын өрийн хэрэгсэл;
- 3.1.4. Төв банкны үнэт цаас;
- 3.1.5. Монголын хөрөнгийн биржийн 1, 2 дугаар ангиллын хувьцаа;
- 3.1.6. Хөрөнгө оруулалтын нээлттэй, хаалттай сан;
- 3.1.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас;
- 3.1.8. Компанийн өрийн хэрэгсэл;
- 3.1.9. Үл хөдлөх хөрөнгө.

3.2. Сангийн хөрөнгийг удирдахдаа энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хэлбэрүүдээс холбогдох хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журмаар даатгалын байгууллагад зөвшөөрсөн хувь хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж болно.

3.3. Банкны хадгаламж болон харилцах дансанд байршуулах гэж "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож, түүнд хяналт тавих журам"-д заасан холбогдох үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн хугацаанд тасралтгүй хангасан, банкны системийн нөлөө бүхий I болон II бүлгийн банкны дансанд хадгалж, байршуулахыг ойлгоно.

3.4. Засгийн газрын өрийн хэрэгсэл гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд

хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг ойлгоно. Үнэт цаас гаргагч нь Засгийн газар байна.

3.5. Төв банкны үнэт цаас гэж Монгол банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно.

3.6. Монголын хөрөнгийн биржийн 1 дүгээр ангиллын хувьцаа гэж арван тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилээрх арилжигдсан үнийн дүн нь биржээр арилжаалагдсан хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь байх шалгуур, шаардлагыг хангасан, Монголын хөрөнгийн биржийн 2 дугаар ангиллын хувьцаа гэж нэг тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, 100 /нэг зуу/ сая төгрөгөөс доошгүй хэмжээний ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх шалгуур, шаардлагыг тус тус хангасан байна.

3.7. Хөрөнгө оруулалтын нээлттэй, хаалттай сан гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5.1 дэх хэсэгт заасан “Үнэт цаасаа бусдад худалдахаар байнга санал болгож, эрэлтийн хэмжээгээр гаргадаг бөгөөд үнэт цаасаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэг буюу нээлттэй”, 38.5.2 дахь хэсэгт “Үүсгэн байгуулагчаас тогтоосон хөрөнгийн хэмжээнд багтаан нийтэд санал болгох хэлбэрээр үнэт цаас гаргаж, зах зээлийн үнээр худалддаг, өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй буюу хаалттай” сангууд хамаарна.

3.8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. дэх хэсэгт “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь энэ хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас байна” гэж заасныг ойлгоно.

3.9. Компанийн өрийн хэрэгсэл гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх хэсэгт заасан “үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг” ойлгоно.

3.10. Үл хөдлөх хөрөнгө гэж Даатгагчийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлыг байрнаас бусад Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, дүрмийн дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй, аливаа зээлийн барьцаанд тавигдаагүй, эсхүл төлбөрийн баталгаа болгоогүй үл хөдлөх хөрөнгийг ойлгоно.

3.11. Гүйцэтгэх захирал нь энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хэлбэрээр сангийн хөрөнгийг удирдахдаа холбогдох хууль, дүрэм, журамд заасан хувь хэмжээг баримтална.

3.12. Гүйцэтгэх захирал нь сангийн хөрөнгийг банкны хадгаламжид байршуулах хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх бол 1 /нэг/ жил хүртэлх хугацаагаар байршуулна.

3.13. Энэ журмын 3.12 дахь хэсгээс бусад хэлбэрээр сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулахаар шийдвэрлэсэн бол Гүйцэтгэх захирал нь хугацааг тухай бүр тогтооно.

3.14. Компанийн Санхүүгийн албаны дарга ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх захирлаас сангийн хөрөнгийг удирдах талаар гаргасан шийдвэрт заасан хугацаанд санхүүгийн гүйлгээг нэн даруй хийнэ.

ДӨРӨВ. ЖУРМЫН ХЯНАЛТ

4.1. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дэргэдэх Аудитын хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина.

4.2. Гүйцэтгэх захирал, Хөрөнгө зохицуулах хороо /цаашид “хороо” гэх/ нь энэ журмын хэрэгжилтийг хангаж, журамд нийцүүлэн үйл ажиллагааг явуулна.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан гаргах бөгөөд ТУЗ-ийн тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулна.

5.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль, журамд заасан хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Хуралд оролцсон гишүүд:.....

Хэлэлцсэн асуудал:.....

Санал хураалтын үр дүн:.....

Хэлэлцсэн хөрөнгө оруулж болох бусад боломжит хэлбэр:.....

Тусгай санал:

ХОРООНЫ ДАРГА, ДЭД ЗАХИРАЛ
ГИШҮҮД:

.....
.....

